



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Мандал сумын Хэрх тосгоны ерөнхий боловсролын сургуулийн
2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2024/244-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn Сүхбаатар сум 2024 он	ТАГ-ын дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Аудитыг гүйцэтгэсэн: "Пийк Ом Аудит" ХХК Утас: 99052418 Цахим хаяг: cheegii9989@gmail.com
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын дүгнэлт	4-5
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	6-12
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	13-17
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	13-14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	14-15
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	15-17
4. Аудитын тайлан	17-20
4.1 Ерөнхий зүйл	17
4.2 Материаллаг байдал	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	19-20
5. Аудитын илрүүлэлт	21-22
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	23

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУГ	Боловсрол Шинжлэх ухааны газар
БШУЯ	Боловсрол Шинжлэх ухааны яам
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

МАНДАЛ СУМЫН
ХЭРХ ТОСГОНЫ ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Т.ЦЭРЭНЛХАМ ТАНАА

2024-А-23 № СЭА-2024/АНН-НА-СТА-ТШЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Мандал сумын Хэрх тосгоны ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Мандал сумын Хэрх тосгоны ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд БШУГ-аас 16,745.5 мянган төгрөгийн хөдөлмөрийн кабинетын хэрэглэгдэхүүн, 28,035.6 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, ширээ сандлыг үнэ төлбөргүйгээр хүлээн авсан байна.

Аудитын гол асуудал

Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг” нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй байна.

Байгууллагын төсөв, санхүүжилтийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Тус сургууль нь 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 5 зорилтын хүрээнд 54 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 83.3 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	181,250,730.35	242,992,061.68
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	58,291,780.27	102,439,355.50
31100	Кассанд байгаа бэлэн мөнгө	0.00	0.00
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	58,291,780.27	102,439,355.50
31210	Төгрөг	58,291,780.27	102,439,355.50
31211	Төрийн сангийн харилцах	58,291,780.27	102,439,355.50
35	БАРАА МАТЕРИАЛ	122,958,950.08	140,552,706.18
35400	Хангамжийн материал	122,958,950.08	140,552,706.18
35410	Бичиг хэргийн материал	141,750.00	0.00
35420	Аж ахуйн материал	105,103,812.38	118,646,512.38
35450	Барилгын засварын материал	0.00	908,000.00
35470	Бусад хангамжийн материал	17,713,387.70	20,998,193.80
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	0.00	0.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,461,094,342.26	1,403,618,050.96
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,461,094,342.26	1,403,618,050.96
39100	Газар	0.00	0.00
39200	Биет хөрөнгө	1,187,855,342.40	1,130,771,551.18
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,115,317,256.39	1,115,317,256.39
39202	Хуримтлагдсан элэгдэл	-142,916,185.12	-180,409,476.64
39203	Авто-тээврийн хэрэгсэл	8,737,500.00	8,737,500.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-1,456,250.04	-2,912,500.08
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	147,246,573.24	174,819,073.24
39206	Хуримтлагдсан элэгдэл	-31,374,475.20	-83,932,066.68
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	102,155,044.57	121,715,455.57
39208	Хуримтлагдсан элэгдэл	-56,938,693.14	-70,401,328.06
39209	Зам, гүүрийн байгууламж	27,952,252.95	27,952,252.95
39210	Хуримтлагдсан элэгдэл	-12,695,796.00	-15,042,986.28
39214	Бусад үндсэн хөрөнгө	2,989,431.56	2,989,431.56
39215	Хуримтлагдсан элэгдэл	-2,615,274.06	-2,871,717.54
39216	Дуусаагүй барилга, байгууламж	0.00	0.00
39217	Ном	31,453,957.25	34,810,656.75
39300	Биет бус хөрөнгө	273,238,999.86	272,846,499.78
39301	Программ хангамж	1,490,000.00	1,490,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-861,250.14	-1,253,750.22
39303	Бусад биет бус хөрөнгө	272,610,250.00	272,610,250.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,642,345,072.61	1,646,610,112.64
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.00	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,642,345,072.61	1,646,610,112.64
51	Засгийн газрын хувь оролцоо	1,642,345,072.61	1,646,610,112.64
51100	Засгийн газрын оруулсан капитал	740,475,009.59	740,475,009.59
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	0.00	0.00
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	740,475,009.59	740,475,009.59
51200	Хуримтлагдсан үр дүн	-16,332,377.51	-12,067,337.48
51210	Өмнөх үеийн үр дүн	-1,775,958,785.12	-16,332,377.51
51220	Тайлант үеийн үр дүн	1,759,626,407.61	4,265,040.03
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс	0.00	0.00
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	918,202,440.53	918,202,440.53

6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,642,345,072.61	1,646,610,112.64
---	--	------------------	------------------

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/			
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,917,575,975.25	1,414,200,345.49
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,777,888,270.41	50,668,164.60
120	Нийтлэг татварын бус орлого	1,777,888,270.41	50,668,164.60
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,255,500.00	5,887,048.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,737,500.00	5,887,048.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,518,000.00	0.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	1,521,321,383.29	28,035,610.50
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	251,311,387.12	16,745,506.10
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,139,687,704.84	1,363,532,180.89
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,014,039,300.00	1,234,173,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,014,039,300.00	1,234,173,200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	125,648,404.84	129,358,980.89
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	125,648,404.84	129,358,980.89
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,157,949,567.64	1,409,935,305.46
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,157,949,567.64	1,409,935,305.46
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,081,415,967.64	1,351,228,085.46
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	710,971,168.41	915,928,800.38
210101	Үндсэн цалин	511,805,479.21	616,291,870.56
210102	Нэмэгдэл	171,059,800.20	253,637,938.29
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	0.00
210104	Урамшуулал	28,105,889.00	45,998,991.53
210105	Гэрээт ажлын хөлс	0.00	0.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	92,299,341.32	113,002,032.19
210201	Тэтгэврийн даатгал	62,303,157.84	77,460,485.94
210202	Тэтгэмжийн даатгал	8,285,067.59	9,282,951.78
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,021,875.28	7,230,264.53
210204	Ажилгүйдлийн даатгал	1,422,090.97	1,712,858.10
210205	Эрүүл мэндийн даатгал	14,267,149.64	17,315,471.84
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	87,321,619.84	120,002,480.89
210301	Гэрэл, цахилгаан	7,348,829.84	8,046,915.23
210302	Түлш, халаалт	76,225,090.00	107,196,375.66
210303	Цэвэр, бохир ус	3,747,700.00	4,759,190.00
210304	Байрны түрээс	0.00	0.00
2104	Хангамж, бараа материалын зардал	19,681,697.58	0.00
2105	Нормативт зардал	24,092,175.00	33,997,825.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	0.00	0.00
210502	Хоол, хүнс	24,092,175.00	33,997,825.00

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,342,004.46	9,356,500.00
210602	Тавилга	1,316,904.46	0.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0.00	0.00
210604	Урсгал засвар	6,025,100.00	9,356,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,039,500.00	8,296,700.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,737,500.00	3,578,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,302,000.00	4,718,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	135,668,461.03	150,643,747.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	16,526,370.00	30,278,805.20
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,012,050.00	12,399,040.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	107,130,041.03	107,965,901.80
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	76,533,600.00	58,707,220.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	76,533,600.00	58,707,220.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	60,916,500.00	58,707,220.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	15,617,100.00	0.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,759,626,407.61	4,265,040.03
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	1,759,626,407.61	4,265,040.03

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,144,943,204.84	1,369,419,228.89
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,255,500.00	5,887,048.00
120	Нийтлэг татварын бус орлого	5,255,500.00	5,887,048.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,255,500.00	5,887,048.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,737,500.00	5,887,048.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,518,000.00	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,139,687,704.84	1,363,532,180.89
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,014,039,300.00	1,234,173,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,014,039,300.00	1,234,173,200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	125,648,404.84	129,358,980.89
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	125,648,404.84	129,358,980.89
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,039,748,424.57	1,302,817,653.66
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,039,748,424.57	1,302,817,653.66
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	963,214,824.57	1,244,110,433.66
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	710,971,168.41	915,928,800.38
210101	Үндсэн цалин	511,805,479.21	616,291,870.56
210102	Нэмэгдэл	171,059,800.20	253,637,938.29
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	0.00
210104	Урамшуулал	28,105,889.00	45,998,991.53
210105	Гэрээт ажлын хөлс	0.00	0.00
210106	Ажилагчдад төлсөн /ТӨҮГ/	0.00	0.00

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	92,299,341.32	113,002,032.19
210201	Тэтгэврийн даатгал	62,303,157.84	77,460,485.94
210202	Тэтгэмжийн даатгал	8,285,067.59	9,282,951.78
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,021,875.28	7,230,264.53
210204	Ажилгүйдлийн даатгал	1,422,090.97	1,712,858.10
210205	Эрүүл мэндийн даатгал	14,267,149.64	17,315,471.84
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	87,321,619.84	120,002,480.89
210301	Гэрэл, цахилгаан	7,348,829.84	8,046,915.23
210302	Түлш, халаалт	76,225,090.00	107,196,375.66
210303	Цэвэр, бохир ус	3,747,700.00	4,759,190.00
2105	Нормативт зардал	24,092,175.00	33,997,825.00
210502	Хоол, хүнс	24,092,175.00	33,997,825.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,025,100.00	9,356,500.00
210604	Урсгал засвар	6,025,100.00	9,356,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,821,500.00	8,296,700.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,737,500.00	3,578,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,084,000.00	4,718,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	36,683,920.00	43,526,095.20
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	24,671,870.00	31,127,055.20
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,012,050.00	12,399,040.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	76,533,600.00	58,707,220.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	76,533,600.00	58,707,220.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	60,916,500.00	58,707,220.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	15,617,100.00	0.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	105,194,780.27	66,601,575.23
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	46,903,000.00	22,454,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	46,903,000.00	22,454,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	46,903,000.00	22,454,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	46,903,000.00	22,454,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-46,903,000.00	-22,454,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	58,291,780.27	44,147,575.23
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	58,291,780.27
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	58,291,780.27	102,439,355.50

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	740,475,009.59	918,202,440.53	-16,332,377.51	1,642,345,072.61
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	740,475,009.59	918,202,440.53	-16,332,377.51	1,642,345,072.61
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	740,475,009.59	918,202,440.53	-16,332,377.51	1,642,345,072.61
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	4,265,040.03	4,265,040.03
20	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	740,475,009.59	918,202,440.53	-12,067,337.48	1,646,610,112.64

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,422,503,800.00	1,325,271,653.66	97,232,146.34	93.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,298,350,800.00	1,195,912,672.77	102,438,127.23	92.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,226,691,000.00	1,137,205,452.77	89,485,547.23	92.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	980,149,300.00	915,928,800.38	64,220,499.62	93.4
210101	Үндсэн цалин	656,092,900.00	616,291,870.56	39,801,029.44	93.9
210102	Нэмэгдэл	274,036,500.00	253,637,938.29	20,398,561.71	92.6
210104	Урамшуулал	50,019,900.00	45,998,991.53	4,020,908.47	92.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	122,518,600.00	113,002,032.19	9,516,567.81	92.2
210201	Тэтгэврийн даатгал	83,312,600.00	77,460,485.94	5,852,114.06	93.0
210202	Тэтгэмжийн даатгал	9,801,600.00	9,282,951.78	518,648.22	94.7
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,841,100.00	7,230,264.53	610,835.47	92.2
210204	Ажилгүйдлийн даатгал	1,960,300.00	1,712,858.10	247,441.90	87.4
210205	Эрүүл мэндийн даатгал	19,603,000.00	17,315,471.84	2,287,528.16	88.3
2105	Нормативт зардал	33,998,700.00	33,997,825.00	875.00	100.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	0.00	0.00	0.00	0.00
210502	Хоол, хүнс	33,998,700.00	33,997,825.00	875.00	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,744,100.00	8,296,700.00	3,447,400.00	70.6
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,578,500.00	3,578,500.00	0.00	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,165,600.00	4,718,200.00	3,447,400.00	57.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	78,280,300.00	65,980,095.20	12,300,204.80	84.3
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	65,881,100.00	53,581,055.20	12,300,044.80	81.3
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,399,200.00	12,399,040.00	160.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	71,659,800.00	58,707,220.00	12,952,580.00	81.9
2132	Бусад урсгал шилжүүлэг	71,659,800.00	58,707,220.00	12,952,580.00	81.9
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	71,659,800.00	58,707,220.00	12,952,580.00	81.9
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,298,350,800.00	1,240,060,248.00	58,290,552.00	95.5

31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,234,173,200.00	1,234,173,200.00	0.00	100.0
310001	Улсын төсвөөс санхүүжих	1,234,173,200.00	1,234,173,200.00	0.00	100.0
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	0.00	0.00	0.00	0.0
320001	Орон нутгийн төсвөөс	124,153,000.00	129,358,980.89	-5,205,980.89	104.2
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	124,153,000.00	129,358,980.89	-5,205,980.89	104.2
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	64,177,600.00	5,885,819.73	58,291,780.27	9.2
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,885,819.73	5,885,819.73	0.00	100.0
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	58,291,780.27	0.00	58,291,780.27	0.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		58,291,780.27		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		102,439,355.50	102,439,355.50	
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1		100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	56	54	2	96.4
620001	Удирдах ажилтан	4	4		100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	36	34	2	94.4
620003	Үйлчлэх ажилтан	16	16		100.0
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	550	550		100.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Мандал сумын Хэрх тосгоны ерөнхий боловсролын сургууль нь "Сурах арга барил эзэмшсэн зөв дадалтай, эх оронч хүүхэд төлөвшүүлэх" гэсэн эрхэм зорилгыг дэвшүүлсэн байна

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Суралцах суурь чадварыг сайжруулах,
- Эрүүл зөв харилцаатай, зөв дадал эзэмшүүлэх,
- Монгол зан заншил, өв уламжлалаа дээдлэх

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- *Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,*
- *Боловсролын ерөнхий хууль 2023 оны 07 дугаар сарын 07-нд батлагдсан,*
- *Хөдөлмөрийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон*
- *БШУС-ын 2023 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 1/2714 тоот албан бичгээр боловсролын байгууллагын төсвийн шинэчлэлийн хүрээнд 1. "ЕБС-д сургалтын тоног төхөөрөмжийн нөхөн хангалт шийдвэрлэх", 2. "Цэцэрлэгт шаардлагатай хүүхдийн тоглоом, наадгай, зөөлөн эдлэл ханган нийлүүлэх, худалдан авах ажиллагааг зохион байгуулах" чиглэлийг хүргүүлсэн гэх мэт.*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд БШУЯ-ны Хяналт, шинжилгээ үнэлгээний газрын Дотоод аудитын хэлтсээс хяналт, шалгалт хийгдээгүй боловч сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мандал сумын Хэрх тосгоны ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан Боловсрол, Шинжлэх Ухааны салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллагуудад мөрдөгдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Мандал сумын Хэрх тосгоны ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 4,265.0 мянган төгрөгөөр буюу 0.3 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	58,291.8	102,439.4	44,147.6
Авлага	-	-	-
Бараа материал	122,959.0	140,552.7	17,593.8
Үндсэн хөрөнгө	1,461,094.3	1,403,618.1	(57,476.3)
Нийт хөрөнгө	1,642,345.1	1,646,610.1	4,265.0
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,642,345.1	1,646,610.1	4,265.0
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,642,345.1	1,646,610.1	4,265.0

Дээрх хүснэгтээс харахад, нөлөө бүхий өөрчлөлт гарсан дараах данснууд байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 102,439.4 мянган төгрөг болж 44,147.6 мянган төгрөгөөр өссөн нь зардлын хэмнэлттэй холбоотой бөгөөд уг хэмнэлтийг Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.9 дэх “Энэ хуулийн 7.7 дахь хэсэг эрүүл мэнд, боловсролын салбарын гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн зарчмаар санхүүждэг байгууллагын төсвийн захирагчид хамаарахгүй” гэж заасны дагуу төрийн сангийн харилцах дансанд үлдэгдлээр тайлагнагдсанаас,
- Бараа материал дансны үлдэгдэл 140,552.7 мянган төгрөг болж 17,593.8 мянган төгрөгөөр өссөн нь БШУГ-аас 16,745.5 мянган төгрөгийн хөдөлмөрийн кабинетын хэрэглэгдэхүүнийг үнэ төлбөргүй авч, төсвийн хөрөнгөөр 125,882.0 мянган төгрөгийн худалдан авалт хийж 125,033.8 мянган төгрөгийг зарцуулснаас,
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,760,441.9 мянган төгрөг болж 50,489.6 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 22,454.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, БШУГ-аас 28,035.6 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, ширээ сандлыг үнэ төлбөргүйгээр хүлээн авснаас тус тус шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд улсын төсвөөс 1,574,052.7 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 105,130.2 мянган төгрөг, нийт 1,679,182.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, зарцуулахаар дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслийн саналыг 486,144.3 мянган төгрөгөөр буюу цалин хөлсийг 465,680.9 мянган төгрөгөөр, нормативт зардлыг 13,261.3 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 6,220.7 мянган төгрөгөөр, тэтгэмж урамшууллын зардлыг 2,990.7 мянган төгрөгөөр, тогтмол зардлыг 3,862.1 мянган төгрөгөөр тус тус бууруулж, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 5,871.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 1,193,038.6 мянган төгрөгөөр баталсан байна.

2023 онд төсөвт 3 удаа өөрчлөлт орж 11 дүгээр сард цалин, НДШ-ийн зардлыг 140,094.6 мянган төгрөгөөр, тогтмол зардлыг 22,884.9 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 2,308.7 мянган төгрөгөөр нийт 165,288.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн улсын төсвөөс 1,234,173.2 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 124,153.0 мянган төгрөгийн санхүүжилт, үндсэн үйл ажиллагааны орлогоос 5,885.8 мянган төгрөгийн орлого бүрдүүлэх, урьд оны үлдэгдлээс 58,291.8 мянган төгрөгийг зарцуулахаар төсвийг нийт 1,422,503.8 мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 13 арга хэмжээг санхүүжүүлэхээр төлөвлөсний дагуу нийт 1,422,504.8 мянган төгрөгийн орлого бүрдүүлснээс урсгал үйл ажиллагаанд 1,325,271.7 мянган төгрөгийг зарцуулж, 97,232.1 мянган төгрөгийг хэмнэж үлдэгдлээр тайлагнасан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,325,271.7 мянган төгрөг буюу 93.2 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлыг хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

		/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр	д/д	Арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	Биелэлт
1	71802 Ерөнхий боловсрол	1	80226- Байр ашиглалтын үйлчилгээ	3,266.3	3,266.3	-	100.0
		2	80312- Сургалт семинар	1,633.1	1,604.7	28.4	98.3
		3	81806-Дотуур байр	60,523.0	57,870.5	2,652.5	95.6
		4	81605- Эрүүл мэндийг дэмжих	5,620.2	5,620.2	-	100.0
		5	81801- Үдийн цай хөтөлбөр	71,659.8	58,707.2	12,952.6	87.3
		6	81816- Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	34,396.6	22,749.7	11,646.9	66.1
		7	81823- Боловсролын багшийн сургалт	7,349.1	7,517.9	(168.8)	102.3
		8	81834- Боловсролын стандарт сургалт	941,937.7	883,157.2	58,780.5	93.8
		9	81835- Сургалтын хэвийн үйл ажиллагаа	160,872.4	149,532.4	11,340.0	90.5
		11	81848-сурах бичгийн түрээс	3,578.5	3,578.5	-	100.0
		12	83603- Дээд шатны төсвөөс	2,308.1	2,308.0	0.1	100.0
		13	80111- Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	129,359.0	129,359.0	(0.0)	100.0
		Нийт				1,422,503.8	1,325,271.7

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны “*Чиглэл хүргүүлэх тухай*” албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хааж, нэмэлт санхүүжилттэй холбоотой гүйлгээг урсгал дансаар дамжуулан гүйцэтгэж, тайланг төсвийн гүйцэтгэлийн тайланд нэгтгэсэн байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, батлуулж, тайлагнаагүй, шууд худалдан авах босго үнээс давсан /2023 оны анх батлагдсан төсвөөр/ үдийн цай хөтөлбөрт 64,176.1 мянган төгрөгийн, дотуур байрны хоолонд 33,998.7 мянган төгрөгийн худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг цахимаар, нийтэд нээлттэй, ил тод зарлаж, гүйцэтгэгчийг шалгаруулалгүйгээр тухай бүр гэрээ байгуулж, худалдан авалтыг хийж, гүйцэтгэсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Мандал сумын Хэрх тосгоны ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн худалдан авалтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг “Пийк Ом Аудит” ХХК-ийн аудитор Б.Наранчимэг, чанарын хяналтыг компанийн захирал Б.Жаргалсайхан, анхан шатны хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Батмөнх, хоёр дахь шатны хяналтыг дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Мандал сумын ерөнхий боловсролын Хэрх тосгоны ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Пийк Ом Аудит” ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 05 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,157,949.6 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 11,579.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт:

Мандал сумын ерөнхий боловсролын Хэрх тосгоны ерөнхий боловсролын сургууль нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Үйл ажиллагаатай холбоотой сурталчилгаа, баяр ёслолын арга хэмжээг зохион байгуулаагүй, төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдаж аваагүй,
- Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй,

- Хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн системийн мэдээлбэл зохих 20 төрлийн 149 мэдээллийг байршуулахаас 145 мэдээлэл байршуулан тухай бүр мэдээлэх 4 мэдээллийг хугацаа хоцроосон байна. Үүнд:

- Санхүүгийн тайлан – 2 удаа,
- Хандив тусламжийн зарцуулалтын тайлан -1
- Дараа жилийн төсвийн төсөл - 1

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар өгсөн шилэн дансны цахим хуудаст мэдээлбэл зохих мэдээллийг хугацаанд нь мэдээлж байх зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана:”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд :

Орон нутагт хүнсний бүтээгдэхүүний бөөний төвлөрсөн цэг байхгүй, зах зээл хомс шалтгаанаар үнийн харьцуулалт хийлгүйгээр “Эвт хишигтэн” ХХК, “Шанзан ташуур” ХХК, “Хуст гуу” ХХК-тай шууд гэрээ байгуулж хоол, хүнсний худалдан авалтыг гүйцэтгэсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх “Захиалагч тендерийн урилгыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, худалдан авах ажиллагааны цахим систем болон хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааг ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримталж зохион байгуулах зөвлөмж өгөх

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

“Пийк Ом аудит” ХХК-ийн 2023 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 217 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2023 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төлбөрийн цахим баримтаар баталгаажуулаагүй 3,574.1 мянган төгрөгийн худалдан авалтыг гүйцэтгэж, бүртгэсэн зөрчилд албан шаардлага, хөрөнгийн ангиллыг уруу бүртгэсэн 27,827.2 мянган төгрөгийн болон шилэн дансны цахим цэсэд 1 мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан зэрэг зөрчлийг арилгах зөвлөмж өгсөн байна.

Өмнөх оны аудитаар өгөгдсөн албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг нотлох баримттай тулган баталгаажуулахад 75.0 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	27,827.2	1	27,827.2	50.0
Албан шаардлага	1	3,574.1	1	3,574.1	100.0
Нийт дүн	3	31,401.3	2	31,401.3	75.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараах асуудлыг дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулж байна. Үүнд:

1. Дээд шатны төсөв захирагчаас төсвийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

Иймд төсвийг бодит гүйцэтгэлтэй нь уялдуулан зардлын бүлэг, зүйл бүрээр төлөвлөж, зарцуулан гүйцэтгэж байх шаардлагатай байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой дараах 3,284.8 мянган төгрөгийн алдааг залрууллаа. Үүнд:

- Үнэ төлбөргүй авсан 3,284.8 мянган төгрөгийн номыг санхүүгийн үр дүнгийн тайланд орлогоор тусгаагүй байна.

Аудитаар нийт **4,437.6** мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс **1,624.8** мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, **2,812.8** мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлээ.

5.1 Төлбөрийн акт

1. Жилийн эцэс буюу тайлант оны 12 дугаар сард шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэлгүйгээр ур чадварын нэмэгдлийг 8 багшид 25 хувиар тооцон / өмнөх саруудад 10-15 хувиар тооцож олгож байсан/ 1,624.8 мянган төгрөгийг илүү олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, Боловсрол шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2021 оны 02 сарын 01-ний өдрийн А/35, А/102 дугаар хамтарсан “Шалгуур үзүүлэлт шинэчлэн батлах тухай” тушаалын 1 дүгээр хавсралтын 10 дахь “Энэхүү баримт бичгийн 4,5-д заасан шалгуур үзүүлэлтийн дагуу хийсэн үнэлгээнд 60.0 ба түүнээс дээш хувь үнэлэгдсэн багш, ажилтны ажлын үр дүн, манлайлал, мэргэжлийн хөгжлийн ахиц дэвшил, амжилтын түвшнийг харгалзан нэмэгдлийг дараах хувиар тогтооно. “цэцэрлэг, сургуулийн түвшинд амжилт гаргасан 10 хувь” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон ур чадварын нэмэгдлийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

5.2 Албан шаардлага

1. Дотуур байрны хүүхдийн хоолны зардлаас үдийн хоолны зардалд **2,812.8** мянган төгрөгийг хөтөлбөр хооронд гүйлгэн зарцуулж гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дахь “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, санхүүгийн тайланг анхан шатны баримтад үндэслэн үнэн зөв илэрхийлж байх албан шаардлага хүргүүлэх,

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй орлогыг тусгаагүй	1	3,284.8			1	3,284.8	1	3,284.8				
Дүн	1	3,284.8			1	3,284.8	1	3,284.8				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Ур чадварын нэмэгдлийг илүү олгосон	1	1,624.8	1	1,624.8								
Зардлыг хөтөлбөр хооронд гүйлгэн зарцуулсан боловч бодитоор тайлагнаагүй	1	2,812.8			1	2,812.8						
Дүн	2	4,437.6	1	1,624.8	1	2,812.8						

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны цахим санд 4 мэдээллийг хугацаа хоцроосон	1				1			
Нийт дүн	1				1			
Бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй	1						1	
Дүн	1						1	
Нийт дүн	2				1		1	-